



Баянбүрдэд ургах тоорой модны байгалийн сэргэн ургалтыг дэмжих арга барил

Говь-Алтай аймаг, Баянтоорой тосгон, Захуйн баянбүрд

Захуйн баянбүрд нь уур амьсгалын хувьд хүйтэвтэр өвөлтэй, зун халуун, хаврын улиралд салхи шуурга ихтэй, нэн хуурай гандуу бүс нутаг юм. Монгол орны ургамалжилтын мужлал (Өлзийхутаг, 1989)-аар цөлийн бүс, Алтайн өвөр говийн тойрогт хамрагдана. Говийн ховор модлог ургамлын байгалийн аясаар сэргээн ургах явц зогсож, нөөц, тоо толгой нь жилээс жилд багасч байна. Тухайлбал: Элдэвнавчит улиас /Тоорой/ (*Populus diversifolia*) сөнөх үедээ орсны нэг шалтгаан бол хамгаалалт сул, байгалийн сэргэн ургалт хэт муу явагдаж байгаатай холбоотой юм. Үрээр сэргэн ургахгүй байгааг зарим эрдэмтэд (Скупченко, 1950) үр боловсрох үед хөрс хэт хуурайшиж, агаар гадаргын цонолтоос болж үр боловсорч цөөхөн хоногийн дотор соёолох чадвараа алдаж байгаатай холбон тайлбарласан байна. Тоорой мод нь голдуу үндэсний ичмэл нахианаас сэргэн ургах бөгөөд үндэсний найлзуурыг мал идэж, гэмтээдгээс болж ургах чадвараа алддаг байна. Тоорой нь говь цөлийн бүсийн хөрсийг хамгаалах, салхи, цасан ба шороон шуурганы хүчийг сааруулах, зуны аагим халуунд хүн, малын сэрүүцэх, амрах сүүдэр болж өгдөг зэрэг экологийн өндөр ач холбогдолтой. Говь, цөлийн бүсэд хонь, ямаа, тэмээ навчиг нь идэх, орон нутгийн иргэд “тооройн буулт” хэмээн тооройгоос ялгардаг бодисыг содын оронд хүнсний зориулалтаар хэрэглэдэг. Тооройн хатсан модлог нь ой модгүй говь, цөлийн хүнд нөхцөлд нутгийн ард иргэд орон гэрийн яс мод, хашаа хороо, худаг доторлох зэрэгт ашигласаар ирсэн. Бидний тооцоогоор Монгол улсын хэмжээнд 25 мянга орчим тоорой байгаа бөгөөд цаашид даруй хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ авахгүй бол устах аюулд орсон болохыг судлаачид тэмдэглэж байна.

Зүүн зургийн тайлбар: Хашиж хамгаалсан талбайд тоорой сэргэн ургасан байдал

Баруун зургийн тайлбар:

Тооройн төглийн ерөнхий төрх байдал



Байршил: Говь-Алтай аймаг, Цогт сум, Баянтоорой тосгон

Газар ашиглалтын төрөл:

Бэлчээрийн газар

Уур амьсгал: Хуурай

MONCAT мэдээллийн сангийн нэр зүй: QA MON-17.

Холбогдох технологи: QT MON-1, QA MON-1, QT MON-3.

Мэдээллийг цуглуулсан

хүн/байгууллага: А.Хауленбек,

Б.Мижиддорж, Л.Мөнхнасан,

Ц.Ганчөдөр - Геоэкологийн

хүрээлэн, Цөлжилтийн судалгааны төв.

Он, сар, өдөр: 2009 оны 11-р сарын 03

Арга барилыг нэвтрүүлсэн хувь хүн, албан байгууллага:

“Говийн Их Дархан Цаазат Газар”-ын хамгаалалтын захиргаа

Холбогдох утас: 0148226526, 99949606

Асуудал, зорилго, бэрхшээл

Тулгарч буй асуудал

1. Тоорой мод нь баянбүрдийн экологийн тэнцвэртэй байдлыг хадгалахад чухал үүрэг, ач холбогдолтой
2. Тоорой мод нь өнөөдрийн байдлаар устаж байгаа бөгөөд байгалийн жамаар сэргэн ургах боломжгүй байгаа юм
3. Тоорой модны байгалийн сэргэн ургалтыг дэмжих замаар баянбүрдийг хамгаалах, нөхөн сэргээх ажлыг өрнүүлэх

Зорилго

Устах аюулд орж буй тоорой модыг хамгаалах, байгалийн нөхөн сэргэлтийг дэмжих.

Шийдвэрлэхэд чиглэгдсэн асуудал

Үндсэн	Товч тодорхойлолт	Шийдвэрлэх арга зам
Бэлчээрийн мал сүргээс хамгаалах	Ямаа, үхэр, хонь, адуу, тэмээ зэрэг бэлчээрийн мал тоорой модны сэргэн ургасан нахиа, найлзуурыг идэж дарангуйлдаг.	Тооройн төгөлийг хашиж хамгаалснаар бэлчээрийн мал сүрэг залуу залуу нахиа, найлзуурыг идэж гэмтээх боломжгүй болно.
Хамгааллын менежмент	Хөрөнгө оруулалт хийх, тогтвортой хашиж хамгаалах, арчлах тогтолцоог бүрдүүлэх.	ГИДЦГ-ын хамгаалалтын захиргааны байгаль хамгаалагч, мэргэжилтэнгүүд ШУ-ны байгуулага, БОАЖЯ, төсөл хөтөлбөрүүдтэй хамтран ажиллах замаар хэрэгжүүлэх боломжтой бөгөөд эхлэл суурийг нь тавиад байна.
Мэдлэгийг түгээн дэлгэрүүлэх	Нутгийн малчин өрхүүд, иргэд тоорой модны ач холбогдол, өнөөгийн устаж буй шалтгааны талаар мэдлэг бага байдаг тул, түлшинд хэрэглэх, мал бэлчээрлүүлэх замаар тоорой модны амьдралт, байгалийн нөхөн сэргэлтэнд дарамт учруулдаг.	Мэдээллийг түгээх, сурталчлан таниулах, сургалт зохион байгуулах замаар тоорой модыг хамгаалах, сэргэн ургалтыг дэмжих идэвхи санаачлагыг орон нутгийн малчид, иргэдийн дунд өрнүүлэх.

Оролцоо, шийдвэр гаргах

Нийгмийн бүлэг



Малчид, газар ашиглагчид




Инжинер, судлаачид

Арга барилд шаардагдах зардал

“Тооройн төлөө” ТББ	80%
ГИДЦГ-ын хамгаалалтын захиргаа	20%
Нийт	100%

Технологи сонголтод шийдвэр гаргагчид: БОАЖЯ, ШУ-ны байгууллагууд, ГИДЦГ-ын хамгаалалтын захиргаа, “Тооройн төлөө” ТББ.

Оролцооны зарчмыг бүрдүүлэгч: ГИДЦГ-ын хамгаалалтын захиргаа, орон нутгийн малчид, иргэд, байгаль хамгаалагч, байгаль орчны байцаагчид.



Мэдлэг түгээн дэлгэрүүлэх

Сургалт: Тодорхой бус

Түгээн дэлгэрүүлэлт: Авирмэд А. Монголын их говьд ургадаг Тоорой (*Populus diversifolia* Schrenk)-н судалгааны зарим асуудалд //”Алтайн өвөр говийн экосистемийн зарим судалгааны тойм” эрдэм шинжилгээний бага хурлын эмхтгэл. УБ. 2004. Х. 19-24., Базарсад Ч. Хауленбек А. Авирмэд А. Монгол орны тоорой, жигд, сухай. УБ. 2003. 50 х., Базарсад Ч. Хауленбек А. Заг, жигд, хайлас, тоорой зэрэг нутгийн мод, сөөгийг тарималжуулах технологи. ЭША-ын тайлан. УБ. 1989-1993. Эх бичмэлээр Ой хайгуул төслийн архивт бий., Базарсад Ч. Хауленбек А. Чулуун Ч. Цөлийн нөхцөлд тоорой, жигд, сухай, загийн тарьц, суулгац ургуулах боломж. //ОАЭШЗТ-ийн хүрээлэнгийн бүтээл. 11. УБ. 1990. Х. 10-23., зэрэг бүтээлүүд хэвлэгдэн олны хүртээл болжээ.

Судалгаа: Элдэвнавчит улиас /тоорой/ нь Монгол улсын улаан номонд орсон нэн ховор ургамал юм. Тоорой модыг тарималжуулах, үржүүлэх, нөөцийг нь нэмэгдүүлэх, тархац, тоо толгойг тогтоохтой холбогдсон суурин болон хээрийн судалгааг (Базарсад, 1989; Хауланбек, 2000; Базарсад, Хауланбек 1993; Базарсад, Хауланбек, Чулуун, 1990; Авирмэд, 1995; 2002; Хауленбек, 2007;) гүйцэтгэжээ.

Орон нутгийн дэмжлэг: Орон нутгийн удирдлагын зүгээс бүхий л талаар дэмжиж ажилладаг.

Арга барилын үзүүлэх үр нөлөө

Мониторинг, үнэлгээ хийсний үндсэн дээр гарсан өөрчлөлтүүд: Мониторинг, үнэлгээ хийгдэж байгаа бөгөөд үр дүн нь тодорхой бус

Хөрс, усны менежмент сайжрах: Тоорой нь ургаж буй орчныхоо хөрсийг салхины элэгдлээс хамгаалж, элсний нүүлтийг тогтворжуулах, баянбүрд бий болгох зэрэг экологийн тэнцвэрийг зохицуулахад онцгой үүрэгтэй.

Бусад төсөл, газар ашиглагч нар арга барилд суралцаж эзэмшсэн эсэх: Тодорхой бус

Тогтвортой байдал: Тоорой модыг хашиж хамгаалах замаар байгалийн сэргэн ургалтыг нь дэмжих, тарьж ургуулан баянбүрдийн нөхөн сэргээлтэнд ашигласнаар түүний нөөцийг хамгаалж тогтвортой байх үндсэн нөхцлийг бүрдүүлж өгнө.

Дүгнэлт

Мониторинг үнэлгээ	Арга барил ба индикатор
Био-физик	Тоорой мод нь байгалийн жамаараа сэргэн ургах боломжгүй болох нь тогтоогдсон бөгөөд энэ нь байгаль цаг уурын эрс тэс уур амьсгал, бэлчээрийн малын нөлөөгөөр хязгаарлагддаг.
Техник	Хашиж хамгаалах замаар тоорой модны байгалийн сэргэн ургалтыг нь дэмжиж өгсөн.
Эдийн засгийн үр ашиг	Тоорой мод нь экологи-эдийн засгийн хувьд чухал ач холбогдолтой. Навчаар нь мал тэжээх, тооройн буултыг хүнсэнд хэрэглэх, модлог мөчрийг нь гэр ахуй, түлшинд хэрэглэхээс гадна баянбүрдийн экологийн орчныг тогтвортой байлгахад үр ашиг нь мэдэгдхүйц өндөр байдаг.
Хамрах талбай	Захуйн баянбүрдийн хэмжээнд өргөн тархалттай ургадаг. Монгол орны хэмжээнд нийт 20.000 гаруй тоорой мод байгаль дээр ургаж байгааг судлаачид тогтоожээ [А.Хауленбек нар 2007].

Давуу тал ба/буюу → хэрхэн тогтвортой байлгах/сайжруулах

→ Баянбүрдийн хэмжээнд цөөн тооны тоорой мод үлдэж хоцорсон нь хамгаалах, нөхөн сэргээх боломжийг бүрдүүлж байна.

→ Хашиж хамгаалах замаар байгалийн сэргэн ургалтын дэмжих боломжтой.

→ Тоорой модыг хашиж байгалийн сэргэн ургалтыг дэмжихээс гадна үрээр тарьж ургуулах агротехникийн үндэслэлийг боловсруулсан байна.

→

Сул тал ба/буюу → хэрхэн даван туулах

→ Өнөөдрийн байдлаар тоорой мод нь байгалийн жамаар нөхөн сэргэж ургах чадваргүй болсон байна.

→ Гэвч энэ ажил нь туршилтын шатандаа явагдаж байгаа бөгөөд эцсийн үр дүнд бие даасан том мод болтол ургуулах боломж тодорхой бус.

→ Говийн бүсэд тооройн үр ургах чадвараа амархан алддаг, хөрөнгө санхүүгийн асуудлаас болж үржүүлэх, нөхөн сэргээх ажил хязгаарлагдмал хэмжээнд хийгдэж байна.

Уур амьсгалын байдал:

Уур амьсгалын үзүүлэлтүүдийг Баянтоорой дахь цаг уурын “Тоорой” станцын мэд: Говь-Алтай аймгийн уур амьсгалын лавлах (2006) ашиглав. Цаг уурын “Тоорой” станци олон жилийн ажиглалтаас үзэхэд Баянтооройд хамгийн хүйтэн үе болох 1-р сард агаар сарын дундаж температур -13.1-18.9 хэм хүйтэн, хамгийн дулаан нь 7-р сард +23.6 хэм дулаан байна. Үнэмлэхүй бага температур нь -40.2 хэм их температур нь +40 хэм хүртэл Олон жилийн үзүүлэлтээс үзэхэд жилд дундажаар 48.3 мм тунадас унах бөгөөд үүний 38 мм буюу 88 % нь дулааны улиралд унадаг. Агаарын харьцангуй чийгшил 30 хувиас доогуу байх үе ургамлын ургалтын хугацаанд 59-73 хоног, үүний 50 орчим хувь нь 5-6 сарууд тохиолддог байна.

Холбоо барих байгууллага: ШУА-ийн Газарзүй - Геоэкологийн хүрээлэн: Цөлжилтийн судалгааны салбар
Утас: 976-11-325487 **Факс:** 976-11-322187
Вебсайт: www.igg.ac.mn, www.geo-eco.mn